

ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР ЗАСГИЙН ГАЗАРТ ҮҮРЭГ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

/Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
эрхлэх асуудлын хүрээнд/

2017.07.05

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасан байдаг.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн тайланд шинжилгээ хийж, ирүүлсэн санал дээр үндэслэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан хууль тогтоомжийн заалтыг хяналтаас хасах саналыг хавсарган хүргүүлж байна.

“Хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг өгсөн шийдвэрийн хэрэгжилтийн 2016 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД ҮҮРЭГ ӨГСӨН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн Монгол Улсын 68 хуулийн 262 заалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын 111 хуулийн 376 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн нь хяналтанд авсан нийт хуулийн 44 буюу 64.7 хувь, 204 заалт буюу 77.9 хувийнх нь хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна. Үлдсэн 67 хуулийн 172 заалтын хэрэгжилтийн мэдээний хувьд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өмнөх онуудад бүрэн хэрэгжиж, хяналтнаас хассан хуулийн хэрэгжилтийн мэдээнүүд болно.

Мэдээнээс үзэхэд давхардсан тоогоор 77 хуулийн 170 заалт буюу 45.3 хувь нь хэрэгжсэн, 56 хуулийн 148 заалт буюу 39.4 хувь нь хэрэгжих шатанд байгаа, 5 хуулийн 9 заалт буюу 1.5 хувь нь хэрэгжээгүй, 11 хуулийн 29 заалт буюу 7.8 хувь нь хугацаа болоогүй, 13 хуулийн 17 заалт буюу 4.5 хувь нь үнэлгээгүй, 2 хуулийн 2 заалт буюу 0.5 хувь нь хүчингүй болсон байна.

2.2. Монгол Улсын хуулиар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын

хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд үүрэг өгсөн заалтын хэрэгжилт

2016 оны жилийн эцсийн байдлаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 9 хуулийн 25 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 14 хуулийн 55 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс 10 хуулийн 32 заалт буюу 58.1 хувь нь хэрэгжсэн, 9 хуулийн 21 заалт буюу 38.1 хувь нь хэрэгжих шатанд, 1 хуулийн 1 заалт буюу 1.8 хувь нь хэрэгжээгүй бол 1 хуулийн 1 заалт буюу 1.8 хувь нь үнэлээгүй ирүүлсэн байна.

Монгол Улсын хуулийн хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	Хууль /Давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	9	25	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	14	55	
Үүнээс:			
- Хэрэгжсэн	10	32	58.1
- Хэрэгжих шатанд байгаа	9	21	38.1
- Хэрэгжээгүй	1	1	1.8
- Үнэлээгүй	1	1	1.8

2.3. Мэдээнд гарсан зөрчил

1. Усны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.25 дахь хэсгийн “Рашааны эмчилгээний чанарыг тогтоосон стандартыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж батлуулах” гэсэн заалтын хэрэгжилтийн талаар “Рашааны эмчилгээний чанарыг тогтоосон стандартын төслийг боловсруулах ажлын хэсгийг БОНХСайдын 2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 162 тоот тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хуралдаанаар энэхүү стандартыг гаргах шаардлагагүй гэж шийдвэрлэснийг хурлын тэмдэглэлд тусгаж, яамны удирдлагад танилцуулж шийдвэрлүүлсэн” гэж тайлагнаж, үнэлээгүй ирүүлсэн байна.
2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны эхний хагас жилийн байдлаар Амьтны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “Анчны үнэмлэх олгох, хураах, хүчингүй болгохтой холбогдсон журмыг хууль зүй, байгаль орчны болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэсэн заалтын хэрэгжилтийг Галт зэвсгийн тухай хууль шинэчлэгдэж байгаатай холбогдуулан журмын төслийг 2013 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 1/62, 1/68 тоотоор Хууль зүйн яаманд хүргүүлээд байна” гэж тайлагнаж, хэрэгжилтийн хувийг “70 хувь” гэж ирүүлж байсан бол 2016 оны жилийн эцсийн мэдээнд “зохион байгуулалтаас шалтгаалан тасарсан”, хэрэгжилтийг “0 хувь”-тай гэж үнэлж ирүүлсэн байна.
3. Мөн 2016 оны эхний хагас жилийн байдлаар хяналтаас хасах саналтай ирүүлсэн 8 хуулийн 29 заалтыг дахин хяналтаас хасах саналтай ирүүлсэн байна.
4. 2016 оны эхний хагас жилийн байдлаар бүрэн хэрэгжиж хяналтаас хасах

саналтайгаар ирүүлж байсан “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэгт заасан “Энэ хуулийн 15.1¹-д заасан үндэсний лавлагаа лаборатори болон багийн ажиллах журмыг Засгийн газар батална” гэсэн заалтын хэрэгжилт 70 хувь болгон, хэрэгжилтийг буурсан үзүүлэлттэй ирүүлсэн байна.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

2016 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газарт үүрэг өгсөн Улсын Их Хурлын нийт 83 тогтоолын 303 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд, бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын нийт 74 тогтоолын 194 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн бөгөөд 9 тогтоолын 109 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 74 тогтоолын 194 заалтын 98 заалт буюу 50.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 73 заалт буюу 37.6 хувь нь хэрэгжих шатанд, 11 заалт буюу 5.7 хувийн хэрэгжих хугацаа болоогүй, 2 заалт буюу 1.0 хувь хэрэгжээгүй, 10 заалт буюу 5.2 хувь нь үнэлгээгүй ирүүлсэн.

3.2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Улсын Их Хурлын 20 тогтоолын 56 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын 13 тогтоолын 27 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс давхардсан тоогоор 11 тогтоолын 13 заалт буюу 48.1 хувь нь хэрэгжсэн, 6 тогтоолын 13 заалт буюу 48.1 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 1 заалт буюу 3.7 хувь нь үнэлээгүй байна.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	УИХ-ын тогтоол /Давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	20	56	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	13	27	
Үүнээс:			
- Хэрэгжсэн	11	13	48.1
- Хэрэгжих шатанд байгаа	6	13	48.1
- Үнэлээгүй	1	1	3.7

3.3. Мэдээнд гарсан зөрчил

¹15.1. Хяналтын байгууллагын дэргэд хүсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн талаарх лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг удирдах, холбогдох лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий үндэсний лавлагаа лаборатори ажиллана.

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өмнө ирүүлсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд “бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай” ирүүлж байсан 2 хуулийн 6 заалтын хэрэгжилтийг “хэрэгжих шатанд” болгон хэрэгжилтийг бууруулж тооцож ирүүлсэн байна. Тухайлбал,
 - “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын 2011 оны 11 дүгээр тогтоолын 5, 6, 7, 9, 12 дахь заалтууд,
 - “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоолын 2.1 дэх заалтын хэрэгжилт буурсан үзүүлэлттэй байна.
2. Мөн Улсын Их Хурлын 4 тогтоолын 4 заалтыг өмнө нь бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай ирүүлж байсан бол дахин хяналтаас хасах саналтайгаар ирүүлжээ. Үүнд:
 - “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2009 оны 39 дүгээр тогтоолын 2.2 дахь заалт;
 - “Ус” үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2010 оны 24 дүгээр тогтоолын 2 дахь заалт;
 - “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2011 оны 02 дугаар тогтоолын 2 дахь заалт;
 - “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2011 оны 11 дүгээр тогтоолын 3 дахь заалтуудын хэрэгжилтийг дахин хяналтаас хасах саналтай ирүүлжээ.
3. “Хүнсний болон хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2012 оны 67 дугаар тогтоолын 1.3 дахь заалтын хэрэгжилтийг 2016 оны эхний хагас жилийн байдлаар ирүүлэхдээ “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар 2014 онд хэлэлцүүлсэн бөгөөд шаардлагагүй гэж түдгэлзүүлсэн болно” гээд хэрэгжилтийг “100 хувь бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай” гэж ирүүлж байсан бол 2016 оны жилийн эцсийн мэдээнд хэрэгжилтийг ижил тайлагнаад “үнэлээгүй” гэж ирүүлсэн байна.

ДӨРӨВ. БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

4.1. Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2016 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хорооноос Засгийн газарт үүрэг өгсөн нийт 93 тогтоолын 633 заалтыг хяналтанд авснаас 128 заалт хэрэгжиж хяналтаас хасагдаж 505 заалт хяналтад үлдсэн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар 55 тогтоолын 272 заалтын буюу хяналтанд авсан нийт заалтын 53.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна. Эдгээр 55 тогтоолын 272 заалтаас 42 тогтоолын 121 заалт буюу 44.4 хувь нь хэрэгжсэн, 37 тогтоолын 92 заалт буюу 33.8 хувь нь хэрэгжих шатанд, 7 тогтоолын 8 заалт буюу 2.9 хувь нь хэрэгжээгүй, 7

тогтоолын 40 заалт буюу 14.7 хувь нь хэрэгжих хугацаа болгоогүй бол 8 тогтоолын 11 заалт буюу 4.04 хувь нь үнэлээгүй ирүүлсэн байна.

4.2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг өгсөн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 9 тогтоолын 34 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэгдэж хяналтанд авсан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 8 тогтоолын 23 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс давхардсан тоогоор 6 тогтоолын 11 заалт буюу 47.8 хувь нь хэрэгжсэн, 5 тогтоолын 12 заалт буюу 52.1 хувь нь хэрэгжих шатанд байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	БОХХААБХ-ны тогтоол /Давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	9	34	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	8	23	
Үүнээс:			
- Хэрэгжсэн	6	11	47.8
- Хэрэгжих шатанд	5	12	52.1

4.3. Мэдээнд гарсан зөрчил

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны эхний хагас жилийн байдлаар бүрэн хэрэгжиж хяналтаас хасах саналтай ирүүлж байсан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 4 тогтоолын 4 заалтыг дахин хяналтаас хасах саналтайгаар ирүүлсэн байна. Үүнд:
 - “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2013 оны 15 дугаар тогтоолын 1.2 дахь заалт;
 - “Монгол орны ойн цэвэрлэгээний талаар авах арга хэмжээний тухай” 2014 оны 04 дүгээр тогтоолын 1.6 дахь заалт;
 - “Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх, ойн нөхөн сэргээлтийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2014 оны 07 дугаар тогтоолын 1.4 дэх заалт;
 - “Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн чадавхийг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2015 оны 07 дугаар тогтоолын 1.4 дэх заалтын хэрэгжилтийг дахин “хяналтаас хасах” саналтай ирүүлсэн байна.
2. “Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн чадавхийг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2015 оны 07 дугаар тогтоолын 1.3-т заасан “Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн үйл ажиллагаанд олон улсын туршлага, арга зүйд үндэслэсэн, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга технологи, менежментийг нэвтрүүлэх, шаардлагатай бага оврын тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлээр хангахад чиглэсэн санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх төсөл, хөтөлбөрийг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх” гэсэн арга хэмжээний хэрэгжилтийг 2016 оны эхний хагас жилийн байдлаар бүрэн хэрэгжсэн тул

“хяналтаас хасах” саналтайгаар ирүүлж байсан бол 2016 оны жилийн эцсийн мэдээнд “хэрэгжих шатанд” болгож, хэрэгжилтийг бууруулан ирүүлсэн байна.

3. Түүнчлэн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлээгүй, хэрэгжилт удаашралтай байгаа зарим арга хэмжээний шалтгаан нөхцөлийг тодруулж, тайлбаргүй, өмнөх ирүүлсэн хэрэгжилтийн мэдээг хуулбарлан ирүүлэх зэрэг зөрчил байна. Тухайлбал,
- “Газар тариалангийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2012 оны 02 дугаар тогтоолын 1.3, 2.1 дэх заалтууд;
 - “Мазаалай баавгайг хамгаалах арга хэмжээний тухай” 2013 оны 15 дугаар тогтоолын 1.2, 1.3 дахь заалтууд;
 - “Монгол орны ойн цэвэрлэгээний талаар авах арга хэмжээний тухай” 2014 оны 04 дүгээр тогтоолын 1.6 дахь заалтуудын хэрэгжилтийг тайлагнахдаа өмнө ирүүлсэн хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээн дэх хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн 10 хуулийн 32 заалт, Улсын Их Хурлын 11 тогтоолын 13 заалт, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 6 тогтоолын 11 заалтыг хяналтаас хасах тухай саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн байна.

Хууль тогтоомж	Хууль тогтоомжийн тоо	Заалтын тоо	Хавсралтын дугаар
Монгол Улсын хууль	10	32	Хавсралт 1
Улсын Их Хурлын тогтоол	11	13	Хавсралт 2
Байнгын хорооны тогтоол	6	11	Хавсралт 3

ЗУРГАА. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх мэдээг ирүүлэхдээ Заалтын хэрэгжилтийг хэрхэн үнэлж байгаа нь тодорхой бус, аргачлалын дагуу үнэлгээ өгөхгүй ирүүлэх зөрчил байна.

Өмнө нь “бүрэн хэрэгжиж хяналтаас хасах саналтай” ирүүлж байсан заалтын хэрэгжилтийг 2016 оны жилийн эцсийн байдлаар “хэрэгжих шатанд” болгож хэрэгжилтийг үнэлсэн байна.

Хууль тогтоомжийн заалтыг хяналтаас хасах тухай саналыг давхардуулж ирүүлэх, хяналтанд байгаа хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг ирүүлэлгүй орхигдуулах, хэрэгжилтийн мэдээг өөрчлөлтгүй ирүүлэх нийтлэг алдааг гаргахгүй байх талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт чиглэл өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

Мэдээллийн сангийн хяналтаас хасах саналтай Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд бүрэн хэрэгжсэн хууль тогтоомжийн нийт 28 хуудас жагсаалтыг хавсаргав.

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭН ДЭХ
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ХУУЛИЙН ЖАГСААЛТ**
/2016 оны жилийн эцсийн байдлаар/

№	Хуулийн нэр, огноо	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай /шинэчилсэн найруулга/ 2012.05.17	13.5 төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмыг Засгийн газар батална. 21.2 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ойд арчилгаа хийх, хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүү бэлтгэх зэрэг ойн цэвэрлэгээний аргаар хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашиглавал төлбөрийг хөнгөлж болох бөгөөд хөнгөлөлтийн хувь, хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.	Засгийн газрын 2014 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 43 дугаар тогтоолоор “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” батлагдав. Засгийн газрын 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн "Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 307 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ойн арчилгаа хийх болон цэвэрлэгээний аргаар түлшний мод бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг хөнгөлөх хувь, хэмжээ тогтоосныг мөрдөн хэрэгжүүлж байна.
2	Хог хаягдлын тухай 2012.05.17	21.2 Энэ хуулийн 21.1-д заасан урамшуулал олгох журмыг Засгийн газар батална. /хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сурталчилж, урамшуулал олгоно/	Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 263 дугаар тогтоолоор “Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сурталчлан урамшуулал олгох тухай” батлагдсан. Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 288 дугаар тогтоолоор “Хог хаягдлын норматив тогтоох аргачлал” батлагдан ажиллаж байна.
3	Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт оруулах тухай 2011.10.06	6.5 “6.5.энэ хуулийн 6.4-т заасан жагсаалтад орсон тухайн бодисын бүртгэл хөтлөх, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, устгах, импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн	Химийн хорт болон аюултай бодисын ангилал батлах тухай” Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын хамтарсан А/356/396 тушаал. -“Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам батлах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын

		захиргааны төв байгууллагатай хамтран батална.	ерөнхий газрын даргын хамтарсан 2007.04.27-ны өдрийн 151/ 126/52 дугаар тушаалыг шинэчлэх ажлын хэсгийг БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-228 дугаар тушаалаар батлуулан ажиллуулсан. “Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам”-ыг БОНХАЖС, ЭМСС-ын хамтарсан 2015 оны А/356/396 тушаалаар баталсан. “Микробиологийн сорьц тээвэрлэхэд тавигдах шаардлага” стандарт боловсруулан, 2016 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар Эрүүл мэндийн Стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлж “Микробиологийн сорьц тээвэрлэхэд тавигдах шаардлага” MNS:6619:2016 стандартыг батлуулсан.
4	Ойн тухай /шинэчилсэн найруулга/ 2012.05.17	10.2 Энэ хуулийн 10.1-д заасан журмыг холбогдох газрын саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. /энэ хэсгийг 2012 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн 2015.09.28найруулсан/ 12.1.3 Ойн үндэсний хөтөлбөрийг батлах; 32.1 Ойгоос тухайн жилд бэлтгэх модны дээд хязгаарыг аймаг, нийслэлийн засаг даргын санал, ой зохион байгуулалтын баримт бичиг, ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэл тус бүрээр тогтооно 32.5 Ойн сангүй болон ойн ашиглах нөөцгүй аймгуудын өрх, аж ахуйн нэгж, байгууллагын түлшний модны хэрэгцээг төвлөрсөн журмаар хангах бөгөөд түлшний модны хөнгөлөлтийн хувь, хэмжээг Засгийн газар тогтооно.	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А-134 дүгээр тушаалаар “Улсын тусгай хэрэгцээний газрын ойд ойн аж ахуйн нэгжийн арга хэмжээ явуулах журам” батлан мөрдөж байна. Засгийн газрын 2001 оны 248 дугаар тогтоолоор батлагдсан “Ойн тухай” үндэсний хөтөлбөр хэрэгжих хугацаа 2015 онд дууссан бөгөөд 2015 оны 05 сарын 14-ны өдрийн УИХ-ын 49 дүгээр тогтоолоор шинээр “Төрөөс ойн талаар баримтлах бодлого” батлагдсан. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А-415 дугаар тушаал гарч 2016 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг аймаг, нийслэл тус бүрээр баталсан. Ойгоос тухай жилд бэлтгэх модны дээд хязгаарыг аймаг, нийслэлд жил бүр шинэчлэн тогтоон хэрэгжүүлж, бүрэн хэвшсэн болно. 2015 оны 07 сарын 08-ны өдрийн УИХ-аар хэлэлцсэн “Ойн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуульд тус заалт нь ҮАБ-ийн үзэл баримтлалтай зөрчилдсөн шалтгаанаар хүчингүйд тооцогдсон тул хяналтаас хасах саналтай байна.

	<p>34.5. Энэ хуулийн 34.1-д заасан эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ, түүнийг олгох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>БОНХАЖ-ын сайдын 2013 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А-153 дугаар тушаалаар “Гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журам” батлагдан, ХЗЯ-нд 2013 оны 08 сарын 26-ны өдрийн 3397 тоотой улсын бүртгэлд бүртгүүлсэн болно. Тус журмаар эрхийн бичиг гарал үүслийн гэрчилгээ олгох асуудлыг журамлан, гэрчилгээний загвар, мод бэлтгэх эрхийн бичгийн загвар батлагдав.</p>
	<p>38.6.Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааг зохицуулсан журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>БОНХАЖ-ын сайдын 2014 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А-166 дугаар тушаалаар “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам” батлагдан, гэрчилгээний загварыг батлуулж, 2014 оны 05 сарын 29-ны өдрийн 3448 тоот улсыг бүртгэлд бүртгэгдсэн болно.</p>
	<p>39.1.Ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасгасан, түүнчлэн дэвшилтэт арга технологи нэвтрүүлсэн иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулах бөгөөд журмыг Засгийн газар батална.</p>	<p>Засгийн газрын 2010 оны 3 сарын 10-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор “Ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасгасан, түүнчлэн дэвшилтэт арга технологи нэвтрүүлсэн иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулах журам” батлагдсан бөгөөд шинээр батлуулах шаардлагагүй, хэвээр мөрдөхөөр тогтсоныг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>
	<p>39.5 Энэ хуулийн 39.2-39.4, 39.10-т заасан урамшуулал олгох журмыг санхүүгийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.</p>	<p>БОНХАЖ-ын сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 03 сарын 31-ны өдрийн А-140/63 тушаалаар “Ойг хамгаалах, тарьц суулгац ургуулах ажлыг урамшуулах журам” батлагдан 2015 оны 04 сарын 29-ны өдрийн 3530 тоотой улсын бүртгэлд бүртгэгдэв.</p>
	<p>4.13 Энэ хуулийн 4.12-т заасан зардлыг төлөх журам, аргачлалыг төрийн захиргааны төв байгууллага тогтооно.</p>	<p>Ойн тухай хуулийн 4.13-т энэ хуулийн 4.12-т заасан зардлыг төлөх журам, аргачлалыг төрийн захиргааны төв байгууллага тогтооно гэж заасан бөгөөд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А-350 дугаар тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.</p>
	<p>6.2 Энэ хуулийн 6.1-д заасан мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална</p>	<p>“Ойн мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журам”-ыг БОНХАЖ-ын сайдын 2013 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн А-53 дугаар тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.</p>
	<p>7.5 Ойн тооллого, ой зохион байгуулалт хийх журмыг Засгийн газар батална. /энэ хэсэгт 2013 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн</p>	<p>Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 105 дугаар тогтоолоор “Ойн тооллого, ой зохион байгуулалт хийх журам” батлагдан мөрдөн ажиллаж байна.</p>

		хуулиар өөрчлөлт оруулсан.	
		8.3 Усны хагалбар дахь байгаль орчны тэнцлийг хангах, хөрсний эвдрэлээс сэргийлэх зорилгоор цармын бүслүүрийн ойн заагийг төрийн захиргааны төв байгууллага тогтооно	Байгаль Орчны сайдын 1998 оны 2 сарын 6-ны өдрийн "Цармын бүслүүрийн ойн зааг тогтоох тухай" 18 дугаар тушаалаар баталсан хилийн заагийг ЗГ-ын хэмжээнд хэлэлцэн хэвээр мөрдөхөөр тогтсон тул үргэлжлүүлэн мөрдөн ажиллаж байна.
		8.5.1 Нийслэлийн ногоон бүсэд хамаарах ойн заагийг Засгийн газар	Нийслэл хотын Ногоон бүсийн хилийн цэсийг Засгийн газрын 1996 оны 326 дугаар тогтоолоор баталсан бөгөөд хэвээр мөрдөж байна.
		8.5.2 Нийслэлээс бусад хотын 30 хүртэл километрийн доторх ногоон бүсэд хамаарах ойн заагийг аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага	Аймгийн төвүүдийн ногоон бүсийн хилийн зааг хэвээр мөрдөгдөж байгаа бөгөөд ногоон бүсийн хилийн заагаа өөрчлөх саналыг бүх аймагт 2015 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн 02/1170 тоотуор хүргүүлсэн бөгөөд одоогийн байдлаар тус яаманд өөрчлөх санал ирээгүй тул хэвээр үргэлжүүлэн мөрдөж байна.
5	Амьтны тухай /шинэчилсэн найруулга/ 2012.05.17	36.3 Амьтныг гадаад улсаас оруулах журмыг төрийн захиргааны төв байгууллага батална.	"Амьтныг гадаад улсаас оруулах, гадаад улсад гаргах журам"-ыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А-359 дүгээр тушаалаар батлан мөрдөж байна.
		7.6 Ховор амьтны жагсаалт, ховор амьтныг агнах, барих зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар батална.	"Ховор амьтны жагсаалт, ховор амьтныг агнах, барих зөвшөөрөл олгох журам"-ыг Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 93 дугаар тогтоолоор батлуулав.
6	Усны тухай хууль 2012.05.17	10.1.29 Усны чанарын болон хаягдал усны стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагатай хамтран батлах.	"Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага" MNS 4943:2015" стандарт, Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. "Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага" MNS 6561:2015 стандартуудыг шинэчлэн боловсруулж, Стандарт хэмжилзүйн үндэсний төвөөр батлуулсан. "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-ыг БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-301 тоот тушаалаар батлуулав. Уг тушаалын зарим хавсралтын хэмжих нэгжид нэмэлт, өөрчлөлт оруулж "Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015.11. 03-ны өдрийн А/378 дугаар тушаалаар батлуулсан.

			“Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Техникийн ерөнхий шаардлага MNS 4943” стандарт, “Ариутгах татуургын системд нийлүүлэх хаягдал бохир усны ерөнхий шаардлага” стандартуудыг шинэчлэн боловсруулж, Стандарт хэмжил зүйн үндэсний төвийн Байгаль орчны стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэн батлагдсан болно.
		10.1.6 Усны нөөцөд учирсан хохирлыг үнэлэх, нөхөн төлбөр тооцох аргачлал батлах;	“Усны нөөцөд учирсан хохирлыг үнэлэх, нөхөн төлбөр тооцох аргачлал”-ыг боловсруулан, БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-388 дугаар тушаалаар батлуулсан.
		20.3 Сав газрын зөвлөлийг байгуулах, ажиллах нийтлэг журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	“Сав газрын зөвлөлийг байгуулах, ажиллах нийтлэг журам”-ыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А-124 дүгээр тушаалаар батлуулсан.
		23.3 Ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэл тогтоох болон энэ үед мөрдөх усны нөөцийн менежментийн талаарх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.	“Ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэл тогтоох болон энэ үед мөрдөх усны нөөцийн менежментийн талаарх журам”-ыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн А-66 дугаар тушаалаар батлуулсан.
		7.2 Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журам”-ыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А-86 дугаар тушаалаар батлуулсан.
7	Ус бохирдуулсны төлбөрийн тухай 2012.05.17	8.4 Энэ хуулийн 8.3-т заасан аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт болон хөнгөлөлтийн хувь хэмжээг заасан журмыг Засгийн газар батална.	Хаягдал усны эзэлхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлалыг боловсруулан БОНХАЖ-ын сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн А/299/204 дүгээр тушаалаар батлуулсан. Ус бохирдуулах аюултай бодисын жагсаалтыг боловсруулан БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн А-294 дүгээр тушаалаар батлуулав.
8	Хөрс хамгаалах, цөлжилтөс сэргийлэх тухай хууль 2012.05.17	5.1 Хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлын зэрэглэлийн шалгуур үзүүлэлт, түүнийг тогтоох аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	БОНХАЖ-ийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/391 тоот тушаалаар “Хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлын зэрэглэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох аргачлал” батлагдав.

		5.6 Хөрс бохирдуулагч химийн бодисын нэр төрөл, хүлцэх агууламжийн жагсаалтыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	“Хөрс бохирдуулагч химийн бодисын нэр төрөл, хүлцэх агууламжийн жагсаалт”-ыг БОНХ-н сайдын 2014 оны А/396 тоот тушаалаар батлуулан мөрдүүлж байна.
9	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай 2012.12.20	12.2 Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрсдэлээс шалтгаалан зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрөл, шошголохтой холбогдсон журмыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	“Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрсдэлээс шалтгаалан зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрөл, шошголохтой холбогдсон журам”-ыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Эрүүл мэндийн сайдын 2013 оны А/46/115 дугаар хамтарсан тушаалаар баталсан.
		13.8 Энэ хуулийн 13.6, 13.7-д заасан ачилтын өмнөх хяналт шалгалтын журмыг Засгийн газар батална. /13.6: хяналтын байгууллага мал, амьтан, ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд импортын өмнөх эрсдэлийн үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд ачилтын өмнөх хяналт шалгалт хийнэ; 13.7: хяналтын байгууллага гадаадын зээл, тусламжаар авах болон мах, сүү, хүүхдийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд ачилтын өмнөх хяналт шалгалтыг хийж болно/.	“Ачилтын өмнөх хяналт, шалгалтын журам”-ыг Засгийн газрын 2013 оны 341 дүгээр тогтоолоор баталсан.
		8.10 Энэ хуулийн 8.2, 8.6, 8.7-д заасны дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журмыг Засгийн газар батална. /8.2: хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дараах тохиолдолд хяналтын байгууллагын шийдвэрээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ хүнсний сүлжээнээс татан авна; 8.6 Хүний амь нас, эрүүл мэндэд аюултай, гарал үүсэл нь тодорхойгүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг энэ хуулийн 8.10-т заасан журмын дагуу устгана;	“Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журам”-ыг Засгийн газрын 2013 оны 172 дугаар тогтоолоор баталсан. Журмын дагуу Мэргэжлийн хяналтын байгууллагын хийсэн шалгалтаар 2015 онд 3766.8 кг, 2911 л, 19537 ширхэг бүтээгдэхүүнийг хураасан, 1511 кг, 46250 ширхэг бүтээгдэхүүнийг буцаасан, 462 кг, 336 л, 3248 ширхэг бүтээгдэхүүнийг татан авсан, 4088 кг, 1586 л, 18527 ширхэг бүтээгдэхүүнийг устгасан дүнтэй байна.

		8.7: буцаан болон татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг мал, амьтны тэжээл, ургамлын бордооны зориулалтаар энэ хуулийн 8.10-т заасан журмын дагуу дахин боловсруулж болно./	
9	Тариалангийн тухай /шинэчилсэн найруулга/ 2016.01.29	21.4Тариалангийн бүтээгдэхүүний хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцох аргачлалыг тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Тариалангийн бүтээгдэхүүний хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцох аргачлалыг боловсруулан ХХАА-н сайдын 2016 оны А-80 тоот тушаалаар баталсан.
Нийт 10 хуулийн 32 заалтыг хяналтаас хасах саналтай байна.			

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭН ДЭХ
ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**
/2016 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	<p align="center">Төрөөс малчдын талаар баримтлах бодлого батлах тухай 2009.06.04 №39</p>	<p>2.2 Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын зорилт, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт жил бүр тусган хэрэгжүүлэх.</p>	<p>Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын зорилт, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэн үндсэн чиглэлд жил бүр тусган хэрэгжүүлж байна. Үүнд: -Үндэсний үйлдвэрүүдийн түүхий эдийн хангамжийг сайжруулах, малын арьс, шир, ноосны чанарыг дээшлүүлэх зорилгоор 2011-2015 онд 408812 малчинд 71.5 мянган тонн ноосны урамшуулалд 112.7 тэрбум төгрөг, 2013-2015 онд 132431 малчны 5.3 сая арьс, ширний урамшуулалд зориулж 20.3 тэрбум төгрөг олгох ажлыг зохион байгуулсан. Ноосны урамшуулалд 2016 онд 22.3 тэрбум, арьс, ширний урамшуулалд 15.7 тэрбум төгрөгийг тус тус олгосон.</p>
2	<p>Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим</p>	<p>1.1 Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын геологи, уул уурхай, газрын кадастрын бүртгэл, мэдээллийг шинэчлэн гаргасны үндсэн дээр эдгээр газрын хилийн заагийг</p>	<p>Усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам"-ыг БОНХАЖ-ын сайд, БХБ-ын сайдын хамтарсан 2016 оны А-230/127 дугаар тушаалаар баталсан. УИХ 2015.02.18-ны өдрийн хуралдаанаараа "Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын</p>

	<p>арга хэмжээний тухай</p> <p>2009.07.16 №55</p>	<p>ТОГТООЖ, олон нийтэд мэдээлэх.</p> <p>1.2 Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн</p>	<p>хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль"-ийг баталсан.</p> <p>Тус нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн үйлчлэлд хамаарах тусгай зөвшөөрлийг журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д 2009.07.16-ны өдөр баталсан Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль батлагдахаас өмнө ойн сан бүхий газарт олгосон ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ойн тухай хуулийн 8.6, 29 дүгээр зүйл, 30.2, 42.1.5-д заасныг хэрэгжүүлэхээр, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг Усны тухай хуулийн 22.3 -т заасны дагуу усны сан бүхий газрын эргээс 200 м-ээр тогтооно гэсэн заалтыг үндэслэн хууль гарахаас өмнө олгогдсон 396 ашиглалтын тусгай зөвшөөрлийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу шийдвэрлэсэн.</p> <p>Засгийн газрын 2011 оны 174, 2012 оны 194 дүгээр тогтоолд 2015.07. 07 -ны өдрийн 289, 2015. 07. 20-ны 302, 2016.03.14-ны өдрийн 155 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт оруулан http://www.legialinfo.mn/ сайтад байршуулан олон нийтэд мэдээлсэн.</p> <p>Хилийн заагийг тогтоох тухай Засгийн газрын 2011 оны 174 дүгээр тогтоолд хамрагдсан алт шороон ордны 242 тусгай зөвшөөрлийг 137 аж ахуйн нэгж эзэмшиж байгаа бөгөөд эдгээрээс нөхөн олговор авах хүсэлт гаргаагүй 66, бүхэлдээ давхцалтай 98 нөхөн олговор нэхэмжилсэн, хэсэгчилсэн давхцалтай 65, үүнээс 40 нь нөхөн олговроо 0 төгрөгөөр тооцуулж давхцалтай талбайн хэсэгтээ хасалт хийлгэж, үлдсэн талбайд үйл ажиллагаа явуулах хүсэлтэй, 25 нь давхцалтай хэсгийн талбайгаа хасуулж нөхөн олговор авав.</p> <p>УИХ-ын 2015.02.18-ны өдрийн хуралдаанаар “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын</p>
--	--	---	---

		<p>сан бүхий газрын хилийн заагийн дотор үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд ашигт малтмалын тухай болон байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах.</p>	<p>хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль” батлагдсан.</p> <p>“Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам” Засгийн газрын 2015 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан.</p> <p>Монгол Улсын Шадар сайд, БОНХАЖ-ын сайд, Уул уурхайн сайдын 2015 оны А/108/358/213 тоот хамтарсан тушаалаар батлагдсан ажлын удирдамжийн дагуу 2015 онд Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Хэнтий, Төв, Сэлэнгэ, Дархан-Ул аймагт Засгийн газрын шийдвэрээр гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, усан сан бүхий газрын хамгаалалтын бүсээс чөлөөлөгдсөн нийт 23 тусгай зөвшөөрөл шалгалтад хамрагдсан.</p> <p>Гомдлын дагуу нийт 41 тусгай зөвшөөрлийг газар дээр нь судалсны 30 урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, 11 усан сан бүхий газрын хамгаалалтын бүс болон бусад хориглох бүстэй давхцалтай байсан.</p> <p>Шалгалтын дүнг УИХ-ын БОХХАА-н Байнгын хороо, ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2016 оны 155 дугаар тогтоолоор 21 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газрын хилийн заагаас чөлөөлсний дагуу дээрх аж ахуйн нэгжүүдэд БОНХАЖ-ын сайдын 2016.04.05-ны өдрийн А/96 тоот тушаалаар шийдвэрлэсэн.</p> <p>Харин 17 аж ахуйн нэгжийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг БОНХАЖ-ын сайдын 2016.03.04-ны өдрийн А/67 тоот тушаалаар хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахыг чиглэл болгон төлөвлөгөө гарган ажилласан.</p> <p>УУХҮЯ-наас Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий</p>
--	--	---	---

			газартай хамтран хяналт, шалгалтын дагуух санал дүгнэлтийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлж, 2015 оны 02 сарын 18-ны өдөр УИХ-аар хэлэлцүүлж, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг батлуулсан.
3	"Ус" үндэсний хөтөлбөр батлах тухай 2010.05.20 №24	2. "Ус" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг зохион байгуулж, холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт .усгаж хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.	"Ус" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2011-2021 он)-г Засгийн газрын 2010.11.21-ний өдрийн 324 дүгээр тогтоолоор батлуулсан. БОАЖ-ын сайдын 2011.08.01-ний өдрийн А-249 дүгээр тушаалаар "Ус" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн график төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлсэн. "Ус" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүр холбогдох яам, газрууд, аймаг, нийслэлийн Засаг дарга нараас авч нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэн ЗГХЭГ, ҮАБЗ, Усны үндэсний хороонд хүргүүлж ажилласан. Жил бүрийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт төв, суурин газруудын ус хангамжийн эх үүсвэрийн усны нөөцийг тогтоох хайгуул, судалгааны болон хөв цөөрөм барих, булаг шандын эхийг хамгаалах ажлын зардлыг тусгуулан хэрэгжүүлэв.
4	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр батлах тухай 2011.01.06 №02	2. Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын хүрээнд хэрэгжүүлэх "уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг зохион байгуулж, холбогдон гарах зардлыг жил бүрийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт	"Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр"-ийн эхний үе шатанд хэрэгжүүлэх 64 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 317 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайланг гаргаж Улсын Их Хурлын Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн болно. Хөтөлбөрийн хүрээнд "Уур амьсгалын өөрчлөлтөнд эмзэг нэн ховор, ховордсон амьтдын эрсдлийн үнэлгээ"

		тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.	хийх ажлыг Монгол Улсын нийгэм-эдийн засгийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, Байгаль хамгаалах сангийн санхүүжилтээр гэрээ байгуулан ажиллаж байна. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2014 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 121 дүгээр зарлигийг боловсруулж, батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад Хөдөө аж ахуй, ой, ус, эрчим хүчний чиглэлээр олон улсын байгууллагын санхүүжилт, дэмжлэгээр 10 сая орчим америк долларын өртөг бүхий хэд хэдэн төсөл хэрэгжүүлж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр Монгол Улс байгаль уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох чадамж бүрдэж, ногоон эдийн засгийн суурь нөхцлийг бүрдүүлж эхэлж байна. Уур амьсгалын өөрчлөлтөнд эмзэг нэн ховор, ховордсон амьтдын эрсдлийн үнэлгээ” хийх ажлын хүрээнд нэн ховор, ховордсон зарим зүйл, амьтдын эрсдлийн үнэлгээ, цаашдын тархалтын талаар төлөв байдлын зураглал бүрэн гарахаар ажиллаж байна. Энэхүү ажлыг хийж хэрэгжүүлэн хэвшсэн болно.
5	Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2011.02.10 №11	3.Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхийн цахилгаан эрчим хүчний урамшууллын хөнгөлөлтийн зөрүүг эрчим хүчний байгууллагад олгох.	Эрчим хүчний зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн №293 тогтоолоор гэр хорооллын иргэдийн цахилгааны шөнийн тарифыг 50 хувиар хөнгөлөх шийдвэр гаргасан. Энэхүү хөнгөлөлтөд Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний 280 гаруй мянган айл өрхүүд хамрагдах бөгөөд цахилгаан халаалт залгах шаардлагатай хүйтний улиралд буюу 2015 оны 12, 2016 оны 1, 2, 3 сар хүртэл оройн 21 цагаас өглөөний 06 цаг хүртэл хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний үнийг 50 хувиар хөнгөлүүлэх боломжтой болж байна. 2017 оны 1 дүгээр сар 01 ний өдрөөс эхлэн гэр хорооллын айл өрхийн цахилгааны үнийг тэглэх шийдвэр гарсан.
6	Хөдөө аж ахуйн гаралтай	3.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн

	<p>бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2011.06.02 №29</p>	<p>эдийн биржийн арилжаанд оролцох биржийн арилжааны зуучлагч /брокер/, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршооны загвар бий болгох.</p>	<p>тухай хуулийг хэрэгжүүлэх, малчид, иргэдийг орон нутгаас биржийн арилжаанд оролцох боломжоор хангах зорилгоор Өмнөговь аймгийн “Хотол таван эрдэнэ хоршоо”-той хамтран биржийн арилжааг 2016 оны 02 дугаар сарын 22-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцох боломжтой хоршоодтой “Хөдөө аж ахуйн бирж” ХХК хамтран ажиллаж байна. Мөн “Жишиг хоршоо” төслийг эхлүүлээд байна.</p>
7	<p>Хүнсний тухай болон хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2012.12.20 №67</p>	<p>1.1 Хүнсний тухай болон хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай: тухай болон хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиудад заасан дүрэм, журам, аргачлал, зөвлөмжийг 2013 оны 2 дугаар сард багтаан батлах.</p>	<p>Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хүрээнд дараах дүрэм, журам, аргачлал, шаардлага, зөвлөмж батлагдсан одоо мөрдөгдөж байна. Үүнд: 1. Монгол хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээ; 2. Экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээ; 3. Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам; 4. Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжгүй өргөн хэрэглээний хүнсний жагсаалт; 5. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн журам; 6. Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн дүрэм, ажиллах журам; 7. Зохистой дадал, НАССР нэвтрүүлэх аргачлал, зөвлөмж; 8. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журам; 9. Түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох, бүртгэл хөтлөх аргачлал; 10. Хүнсний чиглэлийн ажилтанд тавих эрүүл мэндийн шаардлага, үзлэгт хамруулах журам; 11. Ачилтын өмнөх хяналт, шалгалтын журам;</p>

			<p>12.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих аюулгүйн үзүүлэлтийн тодорхойлолт;</p> <p>13.Үндэсний лавлагаа лаборатори болон багийн ажиллах журам;</p> <p>14.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, биобэлдмэлийн болон пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоох;</p> <p>15.Мал, амьтанд зориулан үйлдвэрлэх, импортлох тэжээл, газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглах бордооны аюулгүй байдалд тавих шаардлагыг тогтоох.</p>
8	<p>Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай 2012.12.28 №74</p>	<p>2.2 Хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд олгох урамшуулалд шаардагдах хөрөнгийг 2013 оны төсвийн тодотголд тусгаж, цаашид мөнгөн урамшуулал болон үнэт цаасны хүүгийн зөрүүг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх.</p> <p>2.3 Хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох болон хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд урамшуулал олгох, түүнд хяналт тавих журмыг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах.</p>	<p>2017 оны Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд малын арьс, шир, ноосонд урамшуулал олгохоор тусгав.</p> <p>“Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс ширээ тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд урамшуулал олгох, хяналт тавих, тайлагнах журам”, “Арьс ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, зээлийн зарцуулалт, эргэн төлөлтөд хяналт тавих, тайлагнах журам”-ыг Засгийн газрын 2013 оны 48 дугаар тогтоолоор батлуулж, мөрдөн ажиллаж байна.</p>
9	<p>Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай 2015.01.23 №09</p>	<p>1.1Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын цахилгаан эрчим хүчний үнэд хөнгөлөлт үзүүлэх урамшууллын шалгуур, хэлбэр, цаг, хувь хэмжээг тогтоож, зөрүүг улсын төсвөөс санхүүжүүлэх.</p>	<p>Эрчим хүчний зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн №293 тогтоолоор гэр хорооллын иргэдийн цахилгааны шөнийн тарифыг 50 хувиар хөнгөлөх шийдвэр гаргасан.</p> <p>Энэхүү хөнгөлөлтөд Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний 280 гаруй мянган айл өрхүүд хамрагдах бөгөөд цахилгаан халаалт залгах шаардлагатай хүйтний улиралд буюу 2015 оны 12, 2016 оны 1, 2, 3 сар хүртэл оройн 21 цагаас өглөөний 06 цаг хүртэл хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний үнийг 50 хувиар хөнгөлүүлэх боломжтой болсон.</p>

			<p>2017 оны 1 дүгээр сар 01 ний өдрөөс эхлэн гэр хорооллын айл өрхийн цахилгааны үнийг тэглэх шийдвэр гарч хэрэгжиж эхлээд байна.</p> <p>Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор цахилгаан халаагуур, стандартын шаардлага хангасан дулаалга, хийн түлш, сэргээгдэх эрчим хүч, шахмал болон хагас коксон түлш, сайжруулсан зуух, яндангийн шүүлтүүр хэрэглэж байгаа айл өрхөд цахилгааны үнийн урамшуулал, хөнгөлөлт олгох талаар “Агаарын тухай” хуулийн 6.1.6, “УИХ-ын 2011 оны 11-р тогтоол”, “МУ-ын ЗГ-ын Журам батлах тухай 309-р тогтоол”, “Эрчим Хүчний Зохицуулах Хорооны зохицуулагчдын зөвлөлийн тогтоол”-д тус тус заасан.</p> <p>Дээрхи шийдвэрүүдийн дагуу 2011 онд 21 мянга, 2012 онд 49 мянга, 2013 онд 66 мянга, 2014 онд 69 мянга, 2015 онд 105 мянга, 2016 онд 109 мянган хэрэглэгчийн шөнийн тарифыг 50 % хөнгөлж энэ хугацаанд нийт 11.2 тэрбум төгрөгийн урамшуулал үзүүлсэн байна.</p> <p>Гэр хорооллын айл өрхийн шөнийн тарифыг 2017.1.01-ний өдрөөс 2017.03.31-ний хооронд 100 хувь хөнгөлөхөөр шийдвэрлэж хөнгөлөлт үзүүлж байна.</p> <p>Өнөөдрийн байдлаар УБЦТС-тай гэрээ байгуулан хангагдаж буй нийт 146 мянган гэр хорооллын өрх байна. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хүрээнд гэр хорооллын айл өрхийн цахилгааны шөнийн тарифыг чөлөөлөх, цаашид гэр хорооллын дулаан хангамжийг цахилгаан халаагуурт бүрэн шилжүүлэх арга хэмжээг эрчим хүчний системийн өнөөгийн техникийн нөөц боломжтой уялдуулан 2017 оноос эхлэн үе шаттайгаар хэрэгжүүлнэ.</p> <p>Нийслэлийн гэр хорооллын цахилгаан түгээх сүлжээний нэг хэрэглэгчид ноогдох одоогийн техникийн боломжит чадал 1.7 кВт-аар хязгаарлагдаж байгаа тул эхний ээлжинд түгээх сүлжээний одоогийн бэлэн дэд бүтцийг өргөтгөх арга хэмжээ авч ажиллана.</p> <p>Цаашид нэг хэрэглэгчид ноогдох техникийн боломжит</p>
--	--	--	---

			чадлыг 2 кВт-аас дээш, 4-5 кВт болгоход одоогийн цахилгаан түгээх сүлжээг бүрэн шинэчлэх, өсөн нэмэгдэх хэрэглээг хангах цахилгаан үйлдвэрлэлийн чадлын нөөцийг бий болгох шаардлагатай бөгөөд энэ нь хөрөнгө оруулалт, санхүүжилтийн боломжтой уялдан үе шаттайгаар хэсэгчлэн хэрэгжих юм.
10	Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай 2016.04.14 №35	1.Байгаль орчны тэнцвэрт байдал, байгалийн унаган төрх, түүх, соёлын үнэт өвийг тогтвортой хадгалах, устах аюулд орсон амьтан, ургамлыг хамгаалах зорилгоор байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд онцгой ач холбогдол бүхий Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Тост, Тосон бумбын нурууг байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсугай.	Улсын Их Хурлын Улсын Их Хурлын 2016 оны 04 сарын 14 өдрийн 35-р тогтоолоор Тост, Тосон бумбын нурууг байгалийн нөөц газрын ангилалаар улсын тусгай хамгаалалтад авсан бөгөөд тогтоолын төслийн биелэлтийг хангах зорилгоор олон нийтэд сурталчилах ажлын хүрээнд байгаль орчны мэдээллийн санд бүртгэн, олон нийтэд таниулан сурталчилж ажиллаа. Тост, тосон бумбын нурууны БНГ-ын хамгаалалтын менежментийг Ирвэс хамгаалах ТТБ-д хариуцуулан ажиллахаар хамтран ажиллаж байна. Тусгай хамгаалалтад авсан газрын хилийн заагийг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төсөлд яамдуудаас санал авч нэгтгэн, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2016 оны 04.22-ны 01/2364 албан тоотой холбогдох материалын хамт хүргүүлсэн боловч Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Тост, Тосонбумбын нурууны байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төсөлд яамдуудаас санал авч бэлтгээд байна. Ашигт малтмал, Газрын тосны газарт 2016.09.14-ны өдрийн 03/900 тоотой УИХ-ын тогтоолын 2 дахь хэсэгт “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь заалтын дагуу Монгол Улсын Засгийн газар хилийн заагийг тогтоохыг даалгасан”-ны дагуу хилийн цэсийг тогтоох ажлын хүрээнд тогтоож буй хилийн бүст хамрагдаж буй хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн нөхөх олговрыг тооцуулахаар хүргүүлэн тооцоо судалгааг нэгтгэн дүгнэсэн болно.
11	Хөдөө аж ахуйн “Халх гол”	1.1Дорнод аймгийн Халх гол сумын	ХХАА-н Сайдын 2016 оны А-91, А-110 тоот

	<p align="center">үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах тухай 2016.05.19 №46</p>	<p>нутагт хөдөө аж ахуйн “халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах тухай</p>	<p>тушаалуудаар Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулан орон тооны бүтцийг тогтоож, шаардлагатай санхүүжилтийг ХХААХҮ-н Сайдын багцаас санхүүжүүлэн үйл ажиллагаа явуулж байна.</p>
<p>Нийт Улсын Их Хурлын 11 тогтоолын 13 заалтыг хяналтаас хасах санал ирүүлсэн байна.</p>			

Хавсралт 3

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**
/2016 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	<p>Мод, модон материалын импортыг дэмжихтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2013.05.21 №14</p>	<p>1.Импортоор мод, модон материал оруулж ирж үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн бизнесийг дэмжих зорилгоор гааль, нэмэгдсэн өртөгийн албан татвараас чөлөөлөх, тэдгээрт хөнгөлөлттэй зээл олгох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай.</p>	<p>НӨАТ-аас чөлөөлөх асуудлаар: 2013 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Гаалийн татвараас чөлөөлөх тухай, НӨАТ-ын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиуд батлагдсанаар мод модон материалыг гааль болон НӨАТ-аас 2013.06.07-ны өдрөөс 2017.12.31-нийг хүртэлх хугацаанд чөлөөлсөн заалт бүрэн хэрэгжиж байна.</p> <p>Хөнгөлөлттэй зээл олгох асуудлаар: Мод боловсруулах чиглэлийн үйл ажиллагаа Аж үйлдвэрийн яамны эрхлэх чиг үүрэгт хамаарагддаг бөгөөд 2014 оны 4-р улирлаас хойш тус салбарын 51 иргэн, аж ахуйн нэгж байгууллага Засгийн газрын</p>

			<p>бондын хөрөнгөөс 28,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, олон үйлдвэрүүд технологийн шинэчлэлт хийв.</p> <p>Салбарын аж ахуйн нэгжүүд албан бус мэдээгээр 8,0 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг өөрийн хөрөнгөөр хийсэн байна.</p> <p>Үүнээс ойн цэвэрлэгээнээс гарсан хоёрдогч модон түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэл эрхлэхээр төсөл ирүүлсэн 9 аж ахуйн нэгжид 22,1 тэрбум төгрөгийн зээл олгосоноос 51 иргэн, аж ахуйн нэгжийн 30 гаруй нь 50,0 сая хүртэл төгрөгийн зээл авсан иргэн, жижиг аж ахуйн нэгжүүд юм.</p> <p>Аж үйлдвэрийн яамны мэдээллээр 2015 онд тус салбарт өндөр хүчин чадалтай, орчин үеийн техник технологи бүхий өдөрт 30 иж бүрдэл гал тогооны тавилга үйлдвэрлэх хүчин чадалтай, Герман, Италийн тоног төхөөрөмж бүхий “Долоон болдог” ХХК-ийн тавилгын Европ стандартын үйлдвэр 10 сая орчим ам.долларын хөрөнгө оруулалтаар, Тайваны технологитой жилд 20000 шоометр мод боловсруулж, 60ш модон байшин, 5000 м3 цэвэршүүлсэн зүймэл модон хавтан үйлдвэрлэх хүчин чадалтай “Си энд Жи Лог Хаус” ХХК-ийн үйлдвэр 10 сая гаруй ам.долларын хөрөнгө оруулалттайгаар ашиглалтанд оров.</p>
		<p>2. Ойн нөөцийг хамгаалах, модны хэрэглээ нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх зорилгоор хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх бодлогын баримт бичгийг 1 сарын хугацаанд багтаан боловсруулж байнгын хороонд ирүүлэхийг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, Барилга хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан нарт даалгасугай.</p>	<p>Монгол орны ойн экологийн тэнцвэрийг хадгалах, нөөцийн хомсдолыг хязгаарлан зогсоох, байгаль экологийн онцгой ач холбогдолтой болон доройтсон газар нутгийг ойжуулах, ойн санг арвижуулах ойн нөөцийг иж бүрэн ашиглахад чиглэсэн ойн тогтвортой менежментийг бий болгох зорилгоор “Төрөөс ойн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг УИХ-ын 2015 оны 05-р сарын 14-ний 49 дүгээр тогтоолоор батлуулав.</p> <p>Бодлогын баримт бичигт ойн нөөцийг хамгаалах, тэнцвэржүүлэх талаар дараах зорилтуудыг тусгасан: мод, модон материалын импортыг дэмжих, иргэдийн хэрэгцээг хангахуйц нийлүүлэлт хийх, хууль бус мод</p>

			<p>бэлтгэлийн талаарх мэдээллийг урамшуулах, мод орлох бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх; ашиглалтын ой бүхий нутагт ойн замын сүлжээг сэргээн өргөжүүлж, ойн нөөцийн тогтвортой үйлдвэрлэл эрхлэх, ойн бүтээгдэхүүний гүн боловсруулалтыг дэмжиж, хөдөөгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх; түргэн ургадаг, бүтээгдэхүүнлэг чанар, өгөөж сайтай модыг тарьж ургуулах замаар үйлдвэрлэлийн зориулалттай плантаци байгуулж, ойн тариалан эрхлэх үндэс суурийг тавих; хатсан мод, унанги, бусад ойн хаягдлыг боловсруулж, эдийн засгийн эргэлтэнд оруулах зорилгоор био түлш, шахмал түлш, зүймэл хавтан, наамал, матмал модон эдлэл, фанер, мебелийн хуулга үйлдвэрлэх дэвшилтэд технологи бүхий жижиг, дунд үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх, урамшуулах; үйлдвэрлэлийн зориулалттай мод, модон материалын хэрэгцээг импортын модоор хангах бодлого баримталж, ойн арчилгаа, цэвэрлэгээний огтлолтыг тухайн бүс нутгийн онцлогт тохируулан явуулах замаар иргэдийн модон бүтээгдэхүүний хэрэгцээг хангах; 2011 оны эцсээр ОХУ-ын Иркутск мужийн модны үйлдвэрүүдийн холбоотой хамтран ажиллах санамж бичиг байгуулж ОХУ-ын зарим аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажилласнаар 2012 онд дотоодын 7 компани 2400 гаруй м3 зүсмэл материал импортоор авсан ба цаашид захиалах хэмжээ нэмэгдэх хандлагатай байв. -Мод, модон материалын импортыг дэмжих талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг УИХ-ын БОХХАА-н Байнгын хорооны 2013 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж 14 дугаар тогтоол гарган “Импортоор мод, модон материал оруулж ирж үйл ажиллагаа явуулж байгаа Аж ахуйн нэгжүүдийн бизнесийг дэмжих зорилгоор гааль, нэмэгдсэн өртөгийн албан татвараас чөлөөлөх,</p>
--	--	--	---

			<p>тэдгээрт хөнгөлөлттэй зээл олгох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан шийдвэрийн хүрээнд ОХУ-аас мод импортлож байгаа, импортлохоор ажиллаж байгаа Алтанбулагийн чөлөөт бүс, болон зарим аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлагатай хамтран хөнгөлөлттэй зээл олгох арга замыг судлан “Мод, модон материалын импортыг дэмжих зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг бэлтгэж яамдаас санал авсан боловч төсөвгүйн улмаас энэ ажил зогссон болно.</p> <p>-Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхээр тусгагдсан</p> <p>Ойн нөөцийг хамгаалах, модны хэрэглээ нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх зорилгоор импортын модны гаалийн тарифыг тэглэх тухай санал боловсруулан Байгаль орчны байнгын хорооны хуралдаанд хэлэлцүүлэн татварыг тэглэх шийдвэр гарсан.</p>
2	<p>Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2013.05.29 №15</p>	<p>1.2 “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилтийг 2013 оны 7 сарын 1-ний дотор БОХХБХ-нд танилцуулах.</p>	<p>БОХХААБХ-ны 15 дугаар тогтоолоор дээрхи тогтоолыг эрчимжүүлэх, зээлийн эх үүсвэрт Засгийн газрын бондыг арилжаалж 140,4 тэрбум төгрөгийг бүрдүүлэхийг үүрэг болгосон.</p> <p>УИХ-ын 2012 оны 74 дүгээр тогтоол нь 2013 оны улсын төсөв батлагдснаас хойш батлагдсан, түүнчилэн Засгийн газрын бонд арилжаалагдахдаа хүү өндөр 9 хувиас доошгүй байсан зэрэг шалтгаанаас дээрхи эх үүсвэр бүрдэх боломжгүй байсаар 2014 он гарсан. Энэ талаар мэдээллийг БОХХААБХ-ны хуралд тухай бүр танилцуулж, ирсэн.</p> <p>-Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 198 тогтоол болон 2014 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 217 дугаар тогтоолоор “Арьс ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн төсөлд зээл олгохоор нийт 140,4 тэрбум хүртэл төгрөгийн эх үүсвэрийг</p>

			<p>баталж, арилжааны банкуудаар дамжуулан зээл олгохоор тогтсон.</p> <p>-УИХ-ын 2012 оны 74 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхээр Засгийн газрын 2013 оны 48 дугаар тогтоолоор “Арьс ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцлөөр зээл олгох, зээлийн зарцуулалт, эргэн төлөлтөд хяналт тавих, тайлагнах журам” батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж ирсэн.</p> <p>-Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 198 дугаар тогтоолоор Засгийн газрын 2013 оны 48 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсон.</p> <p>-2014 оны 8 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн дээрхи хөнгөлөлттэй зээлийг дамжуулан зээлдүүлэхээр Хөгжлийн банктэй гэрээ хийсэн арилжааны банкуудаар дамжуулан арьс ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд зээл олгож эхэлсэн байна.</p> <p>2016 оны жилийн эцсийн байдлаар 57 үйлдвэр аж ахуйн нэгжид 86 тэрбум төгрөгийн зээл олгогдоод, зээлийн төсөл хэвийн явагдаж байна.</p> <p>Цаашид энэ чиглэлийн ажил Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжээд явах болно.</p>
3	<p>Монгол орны ойн цэвэрлэгээний талаар авах арга хэмжээний тухай 2014.01.15 №04</p>	<p>1.1 Ойн цэвэрлэгээ хийх шаардлагатай талбайн нарийвчилсан судалгааг хийж, түүнд тулгуурлан ойн цэвэрлэгээг экосистемд сөрөг нөлөөлөлгүйгээр ойн тогтвортой менежментийг ханган зохион байгуулж, ойжуулалт болон нөхөн сэргээх ажлыг төлөвлөн, хэрэгжүүлэх.</p>	<p>Монгол орны ойг цэвэрлэж эрүүлжүүлэх, төлөв байдлыг сайжруулах, түймэр, хөнөөлт шавжийн хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, ойг нөхөн сэргээх, ойн цэвэрлэгээгээр гарсан модоор түлш, ахуйн хэрэгцээний тодорхой хэсгийг хангах, шахмал хавтан, шахмал түлш, барилгын материал болон бусад эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг модон түүхий эдээр хангаж, модны ашиглалтын түвшинг дээшлүүлэх, ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн аж ахуйн нэгжийг чадавхжуулах зорилгоор Засгийн газрын 2014 оны 30 дугаар тогтоолоор “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөрийг баталж хэрэгжүүлж байна.</p>

			<p>БОНХАЖЯ-ны харъяа “Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-ын ойн түймэр, хортон шавж, байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр ургах чадваргүй болсон унанги, хатсан модны нөөцийг тогтоох 2013-2014 оны судалгаагаар улсын хэмжээнд 2,1 сая га талбайд 64,2 сая шоометр хатсан, унасан модны нөөц байгааг тогтоосон.</p> <p>Хэнтий, Булган, Сэлэнгэ аймгийн сум дундын 8 ойн ангиар ойн цэвэрлэгээ хийгдэх талбай тусгаарлалтыг 3200 га талбайд гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулав. Мод, модон материалын зах зээлийн эрэлт, хэрэгцээний тодорхой хэсгийг ойн цэвэрлэгээгээр гарсан модоор хангах, ингэснээр хууль бус мод бэлтгэлийг бууруулах, ойн төлөв байдлыг сайжруулах зорилгоор жил бүр БОНХАЖСайдын тушаалаар ойн цэвэрлэгээний арга хэмжээ хэрэгжих талбай, нөөцийн хэмжээг батлан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>БОНХСайдын 2014 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн “2015 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай” А-382 тоот тушаалаар ойн цэвэрлэгээ хийх талбай, нөөцийн хэмжээг баталсан.</p> <p>Үүний хүрээнд 2015 онд ойн цэвэрлэгээгээр нийт 765,0 мянган шоометр мод үүнээс 607,2 мянган шоометр түлээ, 157,8 мянган шоометр хэрэглээний мод бэлтгэсэн.</p>
		<p>1.2 Ойн цэвэрлэгээ хийхэд ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн болон төрийн бус байгууллагуудыг хамруулан төр хувийн хэвшлийн оролцоог хангаж, шинээр ажлын байр бий болгох, шаардлагатай тохиолдолд ажилчдад мэргэжлийн ур чадвар олгох, дадлагажуулах сургалт зохион байгуулах.</p>	<p>Засгийн газрын 2014 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөрт “Ойн цэвэрлэгээний арга хэмжээнд дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлэх, ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн аж ахуйн нэгж, мэргэжлийн боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Үүнд:</p> <p>Ойн цэвэрлэгээний хүрээнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх иргэд, ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөл, жижиг аж ахуйн нэгжийг хөнгөлттэй зээл,</p>

			<p>зээлийн хүүгийн хөнгөлөлтөөр дэмжин орон нутагт ажлын байр бий болгох; Ойн цэвэрлэгээний ажлыг гардан гүйцэтгэх менежер, мэргэжлийн ажилчин бэлтгэх, давтан сургах; 2015 онд ойн цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэхэд 7 аймгийн 42 сумын 148 аж ахуйн нэгж, байгууллага, 166 ойн нөхөрлөл, 27 иргэдийн бүлгийн 3608 хүн хамрагдан, 1243 иргэн түр болон байнгын ажлын байраар хангагдан ажилласан байна. Үүнээс 355 хүн нь мэргэжлийн үнэмлэх, сертификаттай хүн байсан.</p> <p>Ойн цэвэрлэгээний талаарх сургалтыг 7 аймгийн 23 сумын болон сум дундын ойн анги, 82 сумын удирлага, ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлийн 1318 иргэдийг хамруулан зохион байгуулсан.</p> <p>Сургалтыг танхимд явуулахын зэрэгцээ ойн цэвэрлэгээ хийх талбай дээр нь очиж ургах чадваргүй болсон хуурай мод, унанги, гишүү, мод бэлтгэлийн талбайн үлдэгдэл зэргийг ойгоос цэвэрлэн гаргаж хэрэглээ, түлээ, хаягдал модоор ангилан ялгаж тэдгээрийн хэмжээг тодорхойлох үзүүлэх сургалтыг явуулсан.</p> <p>БОНХАЖ-ын сайдын 2016 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлын зардлын хуваарь баталж эрх шилжүүлэх, төлөвлөгөө батлах тухай” А/24 дүгээр тушаалаар ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад зориулж 400.0 сая төгрөг баталсан.</p>
		<p>1.6 Монгол орны ойг цэвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор төсөл хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, мод орлох бүтээгдэхүүн хэрэглэж байгаа болон хаягдалгүй ногоон технологи боловсруулж нэвтрүүлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг дэмжиж ажиллах.</p>	<p>Засгийн газрын 2010 оны “Журам батлах тухай” 59 дүгээр тогтоолын дагуу ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасгах, дэвшилтэт арга технолонги нэвтрүүлсэн иргэн, нөхөрлөл, аж ахуйн байгууллагыг шалгаруулах журмын дагуу шаардлага хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг жил бүр шалгаруулан урамшуулж байна.</p> <p>Азийн хөгжлийн банкны “Ойн нөхөрлөлийг дэмжих замаар нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх”</p>

			<p>төслийг 2015 оны 4 дүгээр улирлаас хэрэгжүүлж эхэлж байгаа бөгөөд 5 аймгийн 5 суманд шахмал түлшний үйлдвэр байгуулан, 5 сумын 25 нөхөрлөлд мод бутлах төхөөрөмж нийлүүлж, ойн цэвэрлэгээ хөтөлбөртэй уялдуулан 80 байнгын 1600 түр ногоон ажлын байр бий болгохоор төлөвлөн ажиллаж байна.</p> <p>УИХ-ын 2015 оны 05-р сарын 14-ны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс ойн талаар баримтлах бодлого”-ын баримт бичигт заасны дагуу бодлогын зорилтыг хангах цогц хөтөлбөрийн төслийг боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.</p> <p>Монгол орны ойг цэвэрлэж эрүүлжүүлэх, төлөв байдлыг сайжруулах, түймэр, хөнөөлт шавжийн хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, ойг нөхөн сэргээх, ойн цэвэрлэгээгээр гарсан модоор түлш, ахуйн хэрэгцээний тодорхой хэсгийг хангах, шахмал хавтан, шахмал түлш, барилгын материал болон бусад эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг модон түүхий эдээр хангаж, модны ашиглалтын түвшинг дээшлүүлэх, ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн аж ахуйн нэгжийг чадавхжуулах зорилгоор Засгийн газрын 2014 оны 30 дугаар тогтоолоор “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлж байна.</p>
		<p>2.Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг холбогдох эх үүсвэрээс гаргаж дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллан, хэрэгжилтийн талаарх мэдээллийг 2014 оны намрын чуулганы хугацаанд байнгын хороонд ирүүлэхийг Монгол Улсын ерөнхий сайд /Н.Алтанхуяг/-д даалгасугай.</p>	<p>Ойн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжид нэмэлт оруулах ажлын хүрээнд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-156 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, Байгаль орчныг хамгаалах тухай, Ойн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Төрөөс ойн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийн төслийг боловсруулж, Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хороогоор хэлэлцүүлэх үед энэхүү тогтоолоор өгсөн үүргийн биелэлт танилцуулагдсан.</p> <p>2015 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар эдгээр</p>

			<p>хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан бөгөөд УИХ-ын 2015 оны 05-р сарын 14-ны 49 дүгээр тогтоолоор “Төрөөс ойн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг баталсан.</p> <p>БОНХАЖ-ын сайдын 2016 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлын зардлын хуваарь баталж эрх шилжүүлэх, төлөвлөгөө батлах тухай” А/24 дүгээр тушаалаар ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад зориулж 400.0 сая төгрөг баталсан.</p> <p>“Ойн цэвэрлэгээ хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, ойг эдийн засгийн эргэлтэнд оруулах зорилгоор ойн цэвэрлэгээнд ашиглах техник, тоног төхөөрөмжийн судалгаа хийж, ойн цэвэрлэгээний жижиг, дунд оврын техник тоног төхөөрөмжийг цэвэрлэгээний ажилд нэвтрүүлэх, туршилт, үйлдвэрлэлд ашиглах зорилгоор ТБОНӨХБАҮХАТХуулийн дагуу ойн цэвэрлэгээний тоног төхөөрөмж нийлүүлэх нээлттэй тендерийг 2016 оны 04 сарын 26-нд зарлан, тус гэрээт ажлыг зохион байгуулан ажиллаа.</p> <p>Энэхүү ажлын хүрээнд ойн цэвэрлэгээнд ашиглах олон үйлдэлт трактор базагч хошуу, дугуйн гинжийн хамт, цагаалгын ган татлага буюу лебёдка, мод бутлагч төхөөрөмж, мод хагалагч төхөөрөмж, үртэс, зоргодос пресслэгч төхөөрөмж, мод унагах тайрах цахилгаан моторт хөрөө зэрэг ойн цэвэрлэгээний 2 багц техник, тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнийг Төв аймгийн Мөнгөнморьт суман дахь сум дундын ойн анги болон, Сэлэнгэ аймгийн Мандал суман дахь сум дундын ойн ангид гэрээний үндсэн дээр олгоод байна.</p>
4	<p>Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх, ойн нөхөн сэргээлийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2014.04.29 №07</p>	<p>1.4 Хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, урамшууллын арга механизмыг ашиглах, ойн нөөцийн орон нутаг дахь мэргэжлийн удирдлагын үүрэг бүхий ой ангийн тоог хариуцах ойн талбайн хэмжээтэй уялдуулан</p>	<p>БОНХАЖЯ-аас хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2014 оны 5-р сарын 15-ны өдрөөс эхлэн 1 жилийн аян зохион байгуулан ажиллаа.</p> <p>Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, сайн дурын бүлэг байгуулан ажиллуулах, урамшуулал олгох санхүүжилтийн эх үүсвэрийг</p>

		<p>нэмэгдүүлэх зэрэг иж бүрэн арга хэмжээ авах.</p>	<p>тодорхой болгох, мэдээлэл өгсөн, илрүүлсэн сайн дурын бүлэг, цагдаагийн албан хаагчдад урамшуулал олгох чиглэлээр Ойн тухай, БОХ тухай, Тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан, 2015 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлуулан, 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Мод, модон материалын эрэлт нийлүүлэлтийн оновчтой арга хэмжээ авах, хууль зүйн хариуцлагыг чангатгах, иргэдийн оролцоог урамшуулах зэрэг арга механизмыг хэрэглэх замаар хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох зорилтыг Монгол Улсын Их Хурлын 2015 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс ойн талаар баримтлах бодлого”-д тусган ажиллаж байна.</p> <p>Мод, модон материалын төрөлжсөн захуудтай байгуулах “Экологийн хариуцлагын гэрээ”-ний загварыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2015 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн “Экологийн хариуцлагын гэрээний тухай” А-297 тоот тушаалаар баталж, орон нутагт хүргүүлэн модны захуудтай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулав.</p> <p>Засгийн газрын 2012 оны 7-р сарын 25-ны 255 дугаар тогтоолын дагуу сум дундын 36 ойн анги, сумын 5 ойн анги байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Засгийн газрын 2016 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 79 дүгээр тогтоолоор сум дундын 2 ойн ангийг нэмж байгуулав.</p>
5	<p>Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн чадавхыг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2015.07.09 №07</p>	<p>1.1 Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг нэгдсэн зохион байгуулалт, салбар дундын удирдлагаар хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэхтэй холбогдуулан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд</p>	<p>БОАЖЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газарт нөхөрлөл хариуцсан мэргэжилтэн ажиллаж, орон нутгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ажиллаж буй нөхөрлөл хариуцсан мэргэжилтэнүүдээр дамжуулан нийт 1618 нөхөрлөлийг салбар дундын удирдлагаар ханган ажиллаж байна. Тухайлбал; 1.Байгаль хамгаалах нөхөрлөүүдийн шинэчилсэн бүртгэлийг Нөхөрлөлүүдийн Үндэсний холбоотой</p>

		<p>нөхөрлөл хариуцсан нэгж ажиллуулах, энэ чиглэлийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэх.</p>	<p>хамтран 2016 оны 4-6-р сард хамтран зохион байгуулж "Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн мэдээллийн нэгдсэн сан"-г бүрдүүлж байна.</p> <p>Энэ ажлын хүрээнд www.nokhorlol.mne.gov.mn вэбсайтыг шинээр хийж ажиллуулж эхэлсэн. Улсын хэмжээгээр 1600 нөхөрлөл ажиллаж байгаагаас 1281 ойн нөхөрлөл 6.7 мянган өрх, 23496 гишүүнтэйгээр 3.3 сая га ойн санг гэрээгээр эзэмшиж байна.</p> <p>2.Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг нэгдсэн зохион байгуулалт салбар дундын удирдлагаар хангаж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий 36 сум дундын Ойн анги, 5 сумын Ойн анги буюу нийт 41 Ойн анги 21 аймагт үйл ажиллагаа явуулж, 8 аймагт Ойн алба байгуулан ажиллаж байна.</p> <p>3.МБОИЗ болон бусад ТББ-д, Ойн нөхөрлөлүүдийн холбоод зэрэгтэй байнга хамтан ажиллаж сургалт, сурталчилгаа, зөвлөлгөөн зохион байгуулах зэрэг олон талт хамтын ажиллагаа явуулж байна.</p> <p>4.2015 онд нөхөрлөлүүдийн Үндэсний чуулганыг зохион байгуулж, нөхөрлөлүүдийг дэмжих бодлого, түүний эрх зүйн орчин, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд удирдлагаар хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах асуудлыг тодорхойлсон. 2017 оны 4-р сард байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн Үндэсний II чуулганыг зохион байгуулахаар төлөвлөөд байна.</p> <p>5. 2016 оны 11-р сарын 15-ны өдөр БОАЖЯ, Байгаль хамгаалах ногоон хөгжлийн нөхөрлөлүүдийн Үндэсний холбооны хооронд "Хамтын ажиллагааны гэрээ" байгууллаа. Уг гэрээ батлагдсанаар нөхөрлөлүүдийн холбооны төлөөлөл Сайдын зөвлөлд ажиллах, тендерийн хороонд төлөөлөл оролцуулах, үндэсний хэмжээний сүлжээг байгуулж салбарын хэмжээнд олон улсын сургалтад хамрагдах боломжтой болсон.</p> <p>Бэлчээрийн ургамлын ургалтын байдал 2016 онд 6</p>
--	--	---	---

			<p>дугаар сарын сүүлчээр нийт нутгийн 80 гаруй хувьд дунд зэрэг, 10 орчим хувьд сайн, 10 орчим хувьд буюу муу байсан бол 7 дугаар сард нутгийн 80 гаруй хувьд сайн, 15 орчим хувьд дунд, 5 орчим хувьд муу, 8 дугаар сард нутгийн 50 гаруй хувьд сайн, 40 гаруй хувьд буюу дунд, 10 хүрэхгүй хувьд муу үнэлгээтэй байсан нь нутгийн зүүн бүсээс бусад газарт зуншлага сайн байлаа.</p> <p>-Хөдөө аж ахуйн салбарын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангах Засгийн газрын 322 дугаар тогтоолд аймаг, сумын Засаг дарга нарт зарим шаардлагатай хадлангийн талбайг өнжөөх, сэлгэх, өөр аймгийн нутагт хадлан бэлтгэх гэрээ, хэлэлцээр хийж зохицуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг өгсөн. Дорноговь, Төв, Дундговь аймгаас Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Хэнтий аймгийн Норовлин, Дадал, Булган аймгийн Баяннуур сумдад нийт 250 мянган га талбайгаас 190.0 мянган тн хадлан бэлтгэсэн байна.</p>
		<p>1.4Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн гишүүд, идэвхтэн байгаль хамгаалагчдыг мэргэжил арга зүйн дэмжлэг, мэдлэг, мэдээллээр тогтмол хангах, давтан сургалтад хамруулах, үнэмлэх, таних тэмдэгээр хангахад шаардагдах зардлыг төлөвлөж, улсын төсөвт жил бүр тусгуулах арга хэмжээ авах.</p>	<p>1.FAO төслөөс Ойн нөхөрлөлүүдийн гишүүд Ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, ойд арчилгаа хийх хусны нүүрс гаргах, моторт хөрөөний засвар үйлчилгээ, зарим багажны модон иш хийх, Биологийн олон янз байдлыг хамгаалах зэрэг сургалт зохион байгуулсан. Сургалтад давхардсан тоогоор 268 нөхөрлөлийн гишүүд хамрагдсан.</p> <p>2.Байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн Үндэсний чуулган зохион байгуулах, чуулганд оролцогчдын энгэрийн тэмдэг хэвлүүлэх болон бусад арга хэмжээнд нийт 207.7 сая.төг-ийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p>3.Мөн нөхөрлөлүүдэд зориулж 2000 ширхэг идэвхтэн байгаль хамгаалагчийн үнэмлэх олгож, 2016 онд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэхэд зориулж 9.9 сая төгрөг зарцуулсан байна.</p>
6	<p>Чиглэл өгөх тухай 2016.01.22 №01</p>	<p>1.1 Хөдөө аж ахуйн зориулалттай техник, тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис, бордоог импортоор авахад</p>	<p>Засгийн газрын 2016 оны 04-р сарын 04-ний өдрийн 197-р тогтоолоор импортоор оруулж байгаа болон дотооддоо худалдан борлуулах шинэ трактор,</p>

		нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх ажлыг эрчимжүүлэх.	комбайн, машин механизм, гурилын болон бордооны үйлдвэрийн тоног төхөөрөмж, усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисын жагсаалтыг нэмэгдсэн өртгийн албан татвараас 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд чөлөөлүүлэхээр батлуулав.
Нийт 6 тогтоолын 11 заалтыг хяналтаас хасах санал ирүүлсэн байна.			